



Cultivating Patriotism among Citizens, Children, and Youth as the Foundation of Defence Education

Enkhtaivan Dorjderem

Analyst in Charge of defence education and policy, Policy planning department, Strategy and policy planning directorate, Ministry of Defence

E-mail address: E.Dorjderem1982@gmail.com

*Received: 12 January 2026
Accepted: 22 March 2026*

*Revised: 15 March 2026
Published online: 30 March 2026*



ABSTRACT

This article examines the issue of cultivating patriotism and national identity among children and youth, with the aim of identifying key factors influencing this process. The study argues that a crucial driving force in fostering patriotic values and civic consciousness is the establishment and implementation of a comprehensive legal framework on defense education. The research focuses on the need to develop and institutionalize a Law on Defense Education, emphasizing its role in systematically integrating patriotic education, civic values, and national identity formation across all levels of the education system. It highlights that defense education serves as an effective mechanism for shaping responsible, law-abiding, and socially conscious citizens. Furthermore, the article underscores the importance of instilling respect for national heritage, cultural traditions, natural environment, and historical legacy, thereby nurturing an intellectually developed, morally grounded, and future-oriented generation capable of contributing meaningfully to national development and progress.

Keywords: *Defense Education, Patriotism.*

Батлан хамгаалах боловсролын үндэс болох эх оронч үзэл хүмүүжлийг иргэд, хүүхэд залууст төлөвшүүлэх асуудал

Энхтайван Дорждэрэм

Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Батлан хамгаалах боловсрол, сургалтын бодлого хариуцсан шинжээч, E.Dorjderem1982@gmail.com

ХУРААНГУЙ

Энэхүү өгүүлэлд хүүхэд залууст эх оронч үзэл, хүмүүжлийг хэрхэн төлөвшүүлэх тухай асуудлыг хөндөж, түүний гаргалгааг тодорхойлохыг зорьсон бөгөөд эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэхэд гол хүчин зүйл нь бие даасан “Батлан хамгаалах боловсролын тухай” хуультай болох асуудал гэж үзсэн. Судалгааны ажлын шинэлэг тал нь “Батлан хамгаалах боловсролын тухай” хуулийг боловсруулан батлуулах асуудлыг анх хөндөж, түүнд эх оронч үзэл, төлөвшүүлэх хичээлийн агуулгыг бүх түвшиний боловсролын байгууллагын сургалтын

хөтөлбөрт тусгах, мөн хүүхдийн төлөвшилд эцэг эхийн хайр, үр хүүхдээ хумүүжүүлэх арга барил чухал үүрэгтэй байдаг тухай нотлохыг зорьсон нь юм. Хүүхэд залууст эх оронч үзэл төлөвшүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, хуульчилж өгснөөр эх орноо, соёл уламжлалаа, байгаль, эх дэлхийгээ хайрлан хамгаалах ухамсартай, сэтгэл зүрхтэй ирээдүй хойч үе маань өсөн өндийж, эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах чухал ач холбогдолтой болох талаар нотлохыг зорилоо.

Түлхүүр үг: Батлан хамгаалах боловсрол, эх оронч үзэл.

Оршил

Өнөөдөр дэлхий дахинд AI (Artificial intelligence) буюу техник, технологийн дэвшилд суурилсан хиймэл оюун ухааны хэрэгцээ, шаардлага өдөр хоногоор өсөн нэмэгдэж байна. Энэ хэрээр улс орны хөгжил, дэвшилд болон хүүхэд залууст үзүүлэх технологийн хүчин зүйлийн нөлөө хүчтэйгээр илрэн гарч, хэт технологийн хамаарлаас шалтгаалсан гаднын соёлд татагдах явдал өсвөр үеийнхний дунд газар авсаар байгаа билээ.

Тиймээс “**Эх оронч үзэлд суурилсан Батлан хамгаалах боловсрол**”-ын агуулга, хөтөлбөрийг улс орны бүхий л салбаруудын үйл ажиллагаатай уялдуулан зангидаж, цэрэг-эх оронч үзэл төлөвшлийн агуулгыг боловсруулан, бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт тусгуулах асуудлыг ажил хэрэг болгох зайлшгүй шаардлага бид бүхний өмнө тулгарч байна.

Энэхүү асуудлыг хэрэгжүүлэх үндэс нь эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэхэд тулгуурласан “Батлан хамгаалах боловсролын тухай” хуультай болох, түүний эрх зүйн орчныг бүрдүүлэх юм. Улмаар “Эх оронч үзэл хүмүүжил” хичээлийн агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт тусгаж өгснөөр ёс суртахуунтай, аливаа эрсдэл аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвартай, эх оронч үзэл, хүмүүжилтэй иргэнийг бэлтгэж, төлөвшүүлэхэд томоохон түлхэц болно.

Ийм учраас батлан хамгаалах боловсролын үндсэн суурь ухагдахуун болсон эх оронч үзэл, төлөвшлийг ёс суртахууны боловсролтой хослуулан, эх орноо гэсэн сэтгэл зүрхтэй иргэд болон нийгмийг бэлтгэх асуудлыг бүх түвшний боловсролын байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх нь батлан хамгаалах боловсролын нэгэн чухал зорилт юм.

Энэхүү өгүүллээр эх оронч үзэл, хүмүүжлийг хүүхэд залууст төлөвшүүлэх асуудал, батлан хамгаалах боловсролын эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжүүлэх асуудал, түүнийг хэрхэн бэхжүүлэх асуудлын талаар авч үзнэ.

Нэг. Батлан хамгаалах боловсролын суурь үндэс болсон эх оронч үзэл хүмүүжлийг иргэд, хүүхэд залуусын оюун санаанд төлөвшүүлэх асуудал

Аливаа улс, иргэддээ эх оронч үндэсний үзэл, итгэл үнэмшлийг төлөвшүүлсэн эсэх нь батлан хамгаалах боловсролын эрх зүйн орчноо бүрдүүлж чадсан эсэхээс ихээхэн шалтгаалдаг.

“Батлан хамгаалах боловсрол” нь эх оронч үзэл төлөвшлийг иргэд, хүүхэд залууст төлөвшүүлэх, улс орны аюулгүй байдал, эдийн засаг, нийгэм, соёлын тогтвортой байдлыг хангах үндсэн хүчин зүйл бөгөөд өнөөдрийн бидний үйлдэл, хандлагаар илэрч, ирээдүй хойч үед өвлөгдөн үлдэх ёстой үнэт зүйл болсон боловсролын нэгэн чухал тогтолцоо болох учиртай юм. Харин эх оронч үзэл нь улс үндэстний оршин тогтнох, хөгжин дэвжих үндэс суурь, ард иргэдийнх нь эв

нэгдэл, нийтлэг үнэт зүйлсийнх нь илэрхийлэл билээ.

Өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдэд эх оронч үзэл, төлөвшилтэй холбогдох асуудлууд нь хэрхэн уялдаж байгааг судалж үзэхэд 50 шахам хууль, эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдэд шууд тусгагдсан, заримтай нь агуулгын хувьд уялдсан байна.

Гэсэн хэдий ч иргэд, хүүхэд залууст эх оронч үзэл, үндэсний түүх, хэл соёлоороо бахархах бахархлыг төрүүлэх үндсэн зорилготой “Батлан хамгаалах боловсрол”-ын асуудал нь БИЕ ДААСАН ХУУЛЬ болж батлагдан гараагүйтэй холбоотойгоор хий хоосон лоозонгийн шинжтэй зүйл болон хувирч өдийг хүрчээ.

Эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх чиглэлээр сүүлийн 20 шахам жилийн хугацаанд багагүй тооны төсөл, хөтөлбөрүүд төр, засгийн түвшинд батлагдан хэрэгжсэн ч, хэрэгжилт хангалтгүй, үндсэн зорилгоо биелүүлж чадаагүй гэж үзэх үндэслэл байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 295 дугаар тогтоолоор “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2022 оны “Төсөл батлах тухай” 152 дугаар захирамжаар батлагдсан, хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх зорилготой “Бидний бахархал” зэрэг төслүүдийг дурдаж болно.

Дээрх төсөл, хөтөлбөрүүдээс гадна Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр” хэрэгжсэн бөгөөд уг хөтөлбөрийн хугацаа 2024 онд дууссантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Эх оронч Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, түүнийг Батлан хамгаалах яам хариуцан Засгийн газраар батлуулж, хэрэгжүүлэх чиглэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас өгсөн юм (*Г.Занданшатар 2024*).

Энэ чиглэлийн дагуу Батлан хамгаалахын сайдын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/321 дүгээр тушаалаар “Эх оронч Монгол” Үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг томилж, өмнөх жилүүдэд хэрэгжиж байсан төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үр дүнд судалгаа хийхэд хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, мөн хөтөлбөрт жил бүр дүн шинжилгээ хийх үүрэгтэй байсан боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгүй, хайхралгүй орхисон зэргээс тус хөтөлбөрийн хэрэгжилтэд үр дүн гараагүй байна.

Иймд хамгийн зөв шийдэл нь тодорхой хугацаанд хэрэгжээд дуусдаг төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх биш байнга хэрэгждэг, бие даасан, хүүхэд залууст эх оронч хүмүүжлийг төлөвшүүлэх үзэл санаанд тулгуурласан “БАТЛАН ХАМГААЛАХ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ” хуультай болох асуудал бөгөөд уг хуулийг ягштал мөрдүүлэх нь иргэд, хүүхэд залуусын оюун санаанд Эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх эх үндэс болох юм.

Мөн дээрх асуудлаас гадна монголчуудын уламжлалт гэрийн хүмүүжлээр эх оронч үзлийг төлөвшүүлж болно гэж үзэж байна. Ингэхдээ “эхийн хэвлийд үр тогтон, ураг бүрэлдэх тэр мөчөөс эхлэн зөв үзэл ухамсартай аав, ээжийн хайр энэрэл, энергээр дөнгөж бүрэлдэн буй ухамсрыг нь услан тэтгэж, бойжуулах” замаар эхлэх учиртай.

Ингэж чадаж гэмээн эх оронч үндэсний ухамсартай иргэн болж төлөвших үйл

явц ургийн “Удамшлын суурь молекул”-д (ДНХ) нь кодлогдож, тархинд нь суугдаж өгдөг нь “Тенийн инженерчлэл”-ийн шинжлэх ухааны судалгаагаар нотлогдсон асуудал юм (*Гриффит 1928*).

Улмаар эх оронч үзэл сэтгэлтэй эцэг эхийн хайр, энхрийлэлд өсөж хүмүүжих, тоглож наадах бүхий л цаг хугацаанд нь эх орон, байгаль дэлхийгээ хүндэтгэн хайрлах тухай ойлголтыг оюунд нь суулгаж, бага ангиас нь эх орон, дунд ангиас нь аугаа түүх, дайчин замналын талаарх мэдлэгийг өгч, ахлах ангиас нь цэрэгжлийн хичээл, сургалтыг тодорхой хугацаанд, ачаалал багатайгаар олгож, коллеж, их, дээд сургуулиудад тусгай хөтөлбөрөөр үндсэн мэргэжлийн хичээлд нь саадгүйгээр иргэний хамгаалалтын хичээлийг орж, батлан хамгаалах боловсролыг эзэмшүүлснээр энэхүү цогц арга хэмжээ хангагдах болно. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Батлан хамгаалахын сайд, Боловсролын сайдын 2025 оны “Ажлын хэсэг томилох тухай” А/509-А/602 дугаар хамтарсан тушаалаар томилогдсон ажлын хэсэг Ерөнхий боловсролын бага, дунд, ахлах ангийн хөтөлбөрүүдэд тусгах эх оронч үзэл, төлөвшлийн агуулгыг боловсруулж Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 1в/297 дугаар албан Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд хүргүүлэн ажиллаж байгаа юм.

Хоёр. Батлан хамгаалах боловсрол эзэмшүүлэх улс орнуудын туршлага, хэрэгжүүлж буй арга хэмжээ

Манай улсын хувьд “Батлан хамгаалах боловсрол” нь шинэ нэр томьёо мэт боловч энэхүү асуудал нь нийт иргэний хамгаалалтын болон цэрэгжлийн хичээлийн хэлбэрээр Ерөнхий боловсролын болон Техникум, их, дээд сургуулиудад зохион байгуулагдаж байсан, харин гаднын улс орнуудад бол нэн шинэ ойлголт биш юм.

Тухайлбал, МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс “Залуучуудын цэргийн бэлтгэлийг дээшлүүлэх арга хэмжээний тухай” тогтоолыг 1980 оны 10 дугаар сарын 21-нд гаргасан байна. Энэ тогтоолоор 1980-1981 оны хичээлийн жилээс эхлэн цэргийн сургалтыг дахин сэргээж, бүх их, дээд сургуульд цэргийн тэнхим, БХЯ-нд Цэргийн гадуур сургалтын хэлтэс байгуулж, их, дээд сургуульд 500 цагийн, тусгай мэргэжлийн дунд сургууль, техник мэргэжлийн болон ерөнхий боловсролын дунд сургуульд 140 цагийн хичээл оруулах болжээ. 1985 оны байдлаар их, дээд сургуулиудад цэргийн 11 мэргэжлээр 10 мянга орчим оюутан, 37 техник мэргэжлийн болон тусгай дунд сургууль, 300 гаруй ерөнхий боловсролын сургуульд 60 орчим мянган охид, хөвгүүд цэргийн сургалтад хамрагдаж байжээ.

Мөн БХЯ-ны Цэргийн гадуур сургалтын хэлтсийн 1985 оны тайлангаас үзэхэд тухайн жилд их, дээд сургуулиудын цэргийн тэнхимд 104, аймаг, хотын цэргийн хэлтэст цэргийн анхан шатны бэлтгэл хариуцсан 232 багш ажиллаж байсан мэдээ байна (*Ш.Жадамбаа 1996*).

Ардчилал, зах зээлийн нийгэмд шилжсэн цаг хугацаанд төвлөрсөн төлөвлөгөөт нийгмийн үед бүрэлдэн тогтсон байсан батлан хамгаалах боловсрол олгох тогтолцоо үндсэндээ үгүй болсон. Гэсэн хэдий ч 2000-аад оноос улсын эдийн засаг сэргэж эхэлсэнтэй холбогдуулан хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх чиглэлийн тэмцээн уралдааныг зохион байгуулахад эргэн анхаарал хандуулж эхэлсэн.

Тухайлбал цэрэг спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг эргэн сэргээснээс

гадна Ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Эх оронч суралцагч”, “Оюутан цэрэг”, “Байгальд амьдрах арга, ухаан”, “Бид эх орны ирээдүй”, “Бид нэг Монгол”, “Эх орны үнэ цэн”, “Онцгой амралт”, “Бидний бахархал”, “Батлан хамгаалах үйлсэд оюутан, залуус” төсөл зэрэг олон арга хэмжээг зохион байгуулж байна.

Дэлхийн улс орнуудад бүх нийтэд батлан хамгаалах боловсрол олгох асуудалд ихээхэн ач холбогдол өгдөг бөгөөд Литва Улсад цэргийн сургалт бэлтгэлийн төвүүдээр хүүхдүүдэд дроны болон техник сэтгэлгээ хөгжүүлэх болон цэргийн хэргийн анхан шатны мэдлэг олгох сургалтуудыг явуулж байгаа бол Швейцар, Швед зэрэг орнууд Батлан хамгаалах боловсролыг аливаа эрсдэлээс авран хамгаалах, даван туулах зорилгоор ашиглахын сацуу гамшгийн менежментийг сайжруулах, компанийн засаглалыг бэхжүүлэх зэрэг улс орныхоо ихэнх салбаруудад нэвтрүүлж, стратегия тодорхойлон ажиллах болсон нь нэгэнт нууц биш болсон.

Мөн Эстони Улсын боловсролын системд “Үндэсний батлан хамгаалах түүх”, “Онцгой байдал”-ын хичээлүүдийг бага ангиас нь оруулахаар тусгасан байдаг, Израйл Улсын боловсролын системд “Mechina” хэмээх урьдчилсан батлан хамгаалах мэдлэг боловсрол олгодог тогтолцоог сургуулийн өмнөх их дээд сургуульд элсэн суралцахаас 1 жилийн өмнөөс удирдах ур чадвар сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлэх эх оронч үзэл төлөвшүүлэх зорилгоор зохион байгуулдаг (*Eastwood 2017*).

Түүнчлэн Швед Улс “Total Defence” буюу “Нийтийн батлан хамгаалах” хөтөлбөрийг боловсролын тогтолцоондоо нэвтрүүлсэн бөгөөд энэ хөтөлбөрөөр ерөнхий боловсролын сургуулийн хичээлд нийгмийн ухаан, аюулгүй байдлын хичээлийг оруулдаг бол Польш Улс иргэний хамгаалалт, анхны тусламж, аюулгүй байдал батлан хамгаалахын хичээлийг бага ангиас нь эхлэн ордог (*Jeppsson. 2025*).

Дээрх улс орнуудын хувьд тусгаар тогтнолоо өнө удаан хугацаанд хадгалах, оршин тогтнох, гадаад, дотоод асуудлаа бие даан шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлж, бэхжүүлэхэд бүхий л нөөц боломжоо дайчлан Батлан хамгаалах стратегийг хэрэгжүүлдэг бөгөөд үүнийг тусгаар тогтнол, аюулгүй байдлынхаа гол цөм хэмээн үздэг болох нь тодорхой байна.

Тийм ч учраас дэлхийн өндөр хөгжилтэй орнууд гадаад, дотоод аюул, сорилт бэрхшээлийг даван туулах, тэсэн гарах, сэтгэл зүйн бэлтгэлтэй, нийгмийн бүтцийг бий болгож, тэрхүү бүтэц нь удирдан чиглүүлэхэд зохион байгуулалтын хувьд хялбар, хэрэгжүүлэх боломжтой байдаг асуудлын гол оршиж байна. Тухайлбал улс орнууд тайван цагт аюулгүй байдлаа хангах цогц тогтолцоо бүхий бүх нийтийн бэлэн байдлын механизмтай байдаг бөгөөд энэ тогтолцоо нь тайван цагт аюул гамшгийн бүхий л шатанд зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг байна.

Манай улсын хувьд ч гадаад, дотоодоос учрах аюул, сорилт, бэрхшээлийг бодитой үнэлж, амжилттай даван туулж чадсанаараа оршин тогтнолоо баталгаажуулсан байдаг. Бид энэ цаг мөчид ч гэсэн сорилт бэрхшээлүүдтэй нүүр тулж, их гүрнүүдийн нөлөөний бүсэд тусгаар тогтнолоо хадгалж чадаж байгаа нь монгол үндэстний оршихуйн нэг илэрхийлэл болж байгаа юм. Түүнчлэн гадаад, дотоод аюул занал нь зөвхөн уламжлалт болон ердийн цэргийн ажиллагаагаар хязгаарлагдахаа больж, улс төр, эдийн засаг, нийгэм рүү чиглэж, үндэсний эв

нэгдлийг сулруулснаар тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, батлан хамгаалах чадавх тэр чинээгээрээ суларч байдаг тул Батлан хамгаалах боловсролын судалгаа, үнэлгээг хийж, хэрэгжүүлэхээр Батлан хамгаалах яамны холбогдох албан тушаалтнууд ажиллаж байна.

Батлан хамгаалах боловсролын эрх зүйн орчны хувьд Засгийн газрын 2025 оны 7 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар батлагдсан “Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн 2.2.4 дэх заалтад “Бүх нийтийн оролцоонд тулгуурласан батлан хамгаалах боловсролыг тодорхойлж, цэргийн албыг иргэний, түүний дотор залуу үеийн төлөвшил, эх оронч үзэл, хүмүүжлийн орчин байх нөхцөлийг бүрдүүлэх,” гэж, 3.3.1 дэх заалтад “ ... батлан хамгаалах боловсролын үндсэн чиглэлийг тодорхойлон хөгжүүлж, бүх нийтийн үйл хэрэг болгох,” гэж тус тус заасан байна.

Дээрх тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Батлан хамгаалахын сайдын 2025 оны “Батлан хамгаалахын стратеги төлөвлөгөөг батлах тухай” А/36 дугаар тушаалаар салбарын хэмжээнд мөрдөгдөх “БАТЛАН ХАМГААЛАХЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2025-2028”-ыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөөний “Үндсэн чиг үүрэг-2-т “Батлан хамгаалах боловсролын тогтолцоог хөгжүүлэх” гэсэн зорилтыг дэвшүүлэн түүний 1 дүгээрт “**Бүх нийтийн батлан хамгаалах боловсролын үндсэн чиглэл**”-ийг боловсруулж, хэрэгжилтийг хангах” гэж төлөвлөсөн. Тиймээс БХЯ-ны зүгээс Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд “Бүх нийтийн батлан хамгаалах боловсролын Үндсэн чиглэл” баримт бичгийг боловсруулан ҮБХИС, БХЭШХ-ээс санал авч Батлан хамгаалахын сайдын тушаалаар баталгаажуулахаар ажиллаж байна.

Энэхүү “**Бүх нийтийн батлан хамгаалах боловсролын үндсэн чиглэл**”-ийн нэг томоохон зорилго нь хүүхэд залуучуудад эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх асуудал юм.

ДҮГНЭЛТ

Энэхүү өгүүллээр “Эх оронч үзэлд суурилсан, Батлан хамгаалах боловсролыг хүүхэд, залууст эзэмшүүлэх асуудал”-ыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлохыг зорьсон.

Өгүүлэлд эх оронч үзэл төлөвшилтэй иргэдийг бий болгох үндэс нь бие даасан “Батлан хамгаалах боловсролын тухай” хуультай болох асуудал бөгөөд энэхүү асуудал нь хамгийн нэгдүгээрт шийдвэрлэх ёстой асуудал мөн гэж батлахыг оролдлоо. Мөн хүн бүр эх оронч үзэлтэй, эх орноо гэсэн сэтгэлтэй иргэн болж төлөвшихийн тулд “Оюун санааны хувьсгал”-ыг өөрөөсөө эхлэн хийж, өөрийгөө засаж, сайжруулснаар энэхүү үйл явц эхлэх учиртай юм. Үндсэндээ “Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас” гэсэн ардын үгэнд өнөөдрийн бидний өгүүллийн гол “Нюанс” нь нуугдаж байжээ хэмээн дүгнэж болохоор байна.

Учир нь, бид өөрсдийгөө эвдэж, энэ итгэл үнэмшлээрээ үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлж чадах эсэхээс өнөөдрийн бидний эх оронч сэтгэлгээтэй иргэнийг бүтээх асуудал эхлэх бөгөөд энэхүү асуудлыг “Тенийн инженерчлэл”-ийн шинжлэх ухааны аргатай хослуулснаар биеллээ олох боломжтой гэж үзсэн.

Мөн эх оронч үзэл төлөвшилтэй иргэд, хүүхэд залуусыг бэлтгэх чухал хүчин зүйл нь дээр дурдсан “Батлан хамгаалах боловсролын тухай” хуульд бүх түвшний

боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх асуудлыг заавал тусгасан байх зохицуулалтыг оруулж өгөх асуудал юм. Ингэснээр энд томьёологдсон онол арга зүйн үндэс цаашид улам төгөлдөржин, боловсронгуй болж дэлхийн өндөр хөгжилтэй улс орны хэмжээнд хүрч бэхжих үр дүнд хүрнэ гэж дүгнэж байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Eastwood, James. 2017. *“Meaningful Service”*: Pedagogy at Pre-Military Academies in Israel. Cambridge : Cambridge University Press.
2. Jeppsson., Tommy. 2025. *Royal Swedish Academy of Military Sciences, Swedish General Defence Association*. Stockholm: Krigstevenskapsakademien.
3. Г.Занданшатар. 2024. *Үндэсний хөтөлбөрийн төсөл хүргүүлэх тухай ЕТГ-ын Захирамж*. Улаанбаатар.
4. Гриффит, Фредрик. 1928. *“The Significance of Pneumococcal Types”*. London Cambridge University: Journal of Hygiene.
5. Ш.Жадамбаа, Г.Сүхбаатар, Ш.Паламдорж, Б.Даваасүрэн. 1996. *Монгол цэргийн түүхийн товчоон*. УБ: Алтан үсэг компани.

Ашигласан сурвалж, судалгааны бүтээл:

1. “Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль” 2016
2. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоол., 2020., №24
3. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоол., 2020., №52
4. “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндсийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоол., 2015., №85
5. “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2019., №200
6. Ш.Жадамбаа, Г.Сүхбаатар, Ш.Паламдорж, Б.Даваасүрэн. 1996. *Монгол цэргийн түүхийн товчоон*. УБ: Алтан үсэг компани.
7. Монгол Улсын иргэний хамгаалалтын түүх (Түүхийн тойм) УБ., 1999. Т22
8. Н.Жалбажав. *Эх оронч үзэл: Төлөвшил, уламжлал, шинэчлэл* УБ., 2008.
9. Н.Жалбажав. *Эх оронч үзэл, даяаршил* УБ., 2001.
10. Ч.Эрдэнэчулуун. *Монгол Улсын иргэдийг эх орноо батлан хамгаалахад бэлтгэх тогтолцоо, арга зүйн асуудлууд* УБ., 2014.
11. Ш.Гаадамба. 1989. *Утга зохиолын онолын үндэс*. Улаанбаатар.
12. Ц.Тогоо. *Эх оронч үзэл, хүмүүжлийн тухай лекцийн эмхэтгэл*. УБ., 2020.